



## Хураангуй

- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, улам доройтсоор буй тариалангийн хөрсийг хамгаалах, сайжруулахын тулд хөрс хамгаалах технологид шилжих шаардлагатай.
- Хөрс элдэншүүлгийг цомхотгож, цулгүй уриншаас татгалзсанаар хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалж, үржил шимийг нь сайжруулах нөхцөл бүрдэнэ.
- Энэхүү технологийн шилжилт хийхэд хөрсийг хангалттай бордох хэрэгтэй.
- Цомхотгосон буюу тэг элдэншүүлгийн технологи гербицидийн хэрэглээг зайлшгүй шаарддаг.
- Хөрс элдэншүүлгийг цомхотгоход цулгүй уриншийг халж, таримлын сэлгээ нэвтрүүлэх шаардлагатай.
- Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр ургалтын хугацаа урттай шинэ таримлууд тариалах боломж бүрдэж байна.
- Цомхотгосон элдэншүүлэгт шилжихэд агрономийн зохих мэдлэг, ур чадвар шаардагдана.

## Монгол орны усалгаагүй тариалан

### Тогтвортой газар тариалангийн систем

Монгол оронд газар тариаланд уламжлалт технологийг өргөн хэрэглэсээр буй бөгөөд үүнд уринш-буудайн сэлгээ багтана. Газар тариалангийн салбарын хөгжилд тулгарч буй томоохон сорилт бол уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудал юм. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр ургамал ургахад шаардлагатай ус, чийг багасч, хөрсний үүршилт нэмэгдэж, хүчтэй салхи шуургын давтамж олширч, хур тунадасны хуваарилалт өөрчлөгдөж буй тул газар тариаланг цаашид эдгээр өөрчлөлтүүдэд дасан зохицсон хэлбэрээр эрхлэх шаардлагатай болж байна. Түүнчлэн олон жил зохисгүй ашигласны улмаас доройтсон талбайн хөрсийг хамгаалах, сайжруулахад анхаарал хандуулах цаг болжээ.

Усалгаагүй тариалангийн хувьд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох гол шийдэл нь хөрс хамгаалах технологи юм. Хөрс хамгаалах технологид хөрс элдэншүүлгийг цомхотгох, цулгүй уриншийг халах гэсэн хоёр зарчмыг баримталдаг. Эдгээр зарчмыг мөрдсөнөөр хөрсний нэвчилт сайжирч, салхины элэгдэлд өртөмтгий байдал нь буурч, үржил шим нь тогтворждог. Хөрс хамгаалахын тулд заавал тэг элдэншүүлэгт шилжих шаардлагагүй. Тэг элдэншүүлгийн технологи маш нарийн төвөгтэй, нилээд туршлага шаарддаг тул тариаланчид нийтээрээ авч хэрэгжүүлэхэд хүндрэлтэй. Харин үүнээс арай дөхөмтэй хувилбар болох минималь элдэншүүлэг буюу цомхотгосон элдэншүүлгийн технологийг нэвтрүүлснээр хөрсийг харьцангуй цөөн удаагийн, гүехэн хөндөлтөөр тариалалтад бэлтгэхийн сацуу хог ургамлын тархацыг хянах боломж бүрдэнэ.

Хөрс элдэншүүлгийг цомхотгож, цулгүй уриншаас татгалзах технологийн шилжилт хийхэд дараах асуудлуудад анхаарах хэрэгтэй:

Implemented by



1. Хог ургамлын тархалт нэмэгдэх тул ургамал хамгааллын бодис, арга хэмжээг хангалттай хэмжээнд төлөвлөн, хэрэгжүүлэх;
2. Цулгүй уриншийг сэлгээнээс халснаар таримлын өвчин, хортоны тархалт нэмэгдэж болзошгүй тул таримлын сэлгээг зөв зохион байгуулах;
3. Хөрс элдэншүүлгийг цомхотгосноор хөрсний органик бодисын эрдэсжилт буурч, улмаар ургамалд хүртээмжтэй шим тэжээлийн бодисын хэмжээ багасах тул уг дутагдлыг тариалалтын үед хангалттай бордох замаар нөхөх шаардлагатай.

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр жилийн дундаж температур нэмэгдэж буй тул цаашид таримлын ургалтын хугацаа уртсах төлөвтэй байна. Иймд таримлын сэлгээг эрдэнэшиш, сорг будаа зэрэг шинэлэг таримлуудаар баяжуулж, таримлын нэр төрлийг олшруулах боломж бүрдэж буйг ашиглах нь зүйтэй.

### **Зөвлөмж**

- ❖ Хөрс хамгаалах, ургац тогтворжуулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицын тулд хөрс элдэншүүлгийг цомхотгож, цулгүй уриншаас бүрэн татгалзах;
- ❖ Цомхотгосон технологид шилжих явцад ургамал хамгаалалд анхаарах. Цомхотгосон буюу тэг элдэншүүлгийн технологи гербицидийн хэрэглээг зайлшгүй шаарддаг;
- ❖ Тариалангийн талбайн хөрсийг шинжилгээнд бүрэн хамруулж, шинжилгээний дүнд үндэслэн боловсруулсан тун, нормоор бордох. Хөрс шинжилгээний лабораториудын хүчин чадлыг сайжруулах, бүс, орон нутгийн лабораториуд шинээр байгуулах, шинжээчдийг давтан сургаж, тариаланчдад бордооны зөвлөмж өгөх чадвартай болгоход анхаарах шаардлагатай;
- ❖ Сэлгээнд шинэ таримлууд тариалахад нь тариаланчдад тусламж үзүүлэх. Ялангуяа уг таримлуудыг борлуулах зах зээлд зуучлахад анхаарч ажиллах. Монгол орон газарзүйн байрлалын хувьд газар тариалангийн бүтээгдэхүүн экспортлох бүрэн боломжтой;
- ❖ Тариаланчид, салбарын эрдэмтэн судлаачид, бодлого боловсруулагчид, ХАА-н техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодис үйлдвэрлэгчид, борлуулагчдын хамтын ажиллагаанд тулгуурласан урт хугацааны талбайн туршилт судалгаа, тэдгээрийн үр дүнг сурталчлах арга хэмжээнүүдийг Монгол орны тариалангийн бүс нутгуудад бүсчилсэн байдлаар зохион байгуулах;
- ❖ Мэдлэг, мэдээлэл дамжуулах арга хэмжээнүүд, жишээлбэл Казакстан, Өмнөд Сибирь зэрэг ойролцоо уур амьсгалтай бүс нутгуудад туршлага судлах аялал, эсвэл тариалангийн цомхотгосон технологийн сэдвээр олон улсын хурал, зөвлөгөөн зохион байгуулж, хөрс хамгаалах технологийг хөгжүүлсэн улс орнуудын туршлагаас суралцах;
- ❖ Төрөөс тариаланчдад үзүүлж буй дэмжлэгийг хөрсний үржил шимийг сайжруулах дэвшилтэт технологийг нэвтрүүлэх үйл ажиллагаатай холбож зохион байгуулах. Тухайлбал хөнгөлөлт, урамшууллыг гербицид, бордоо, чанартай үр болон тэг, цомхотгосон технологид нийцсэн үрлэгч, хор цацагч зэрэг техник, тоног төхөөрөмжид зарцуулах;
- ❖ Тогтвортой газар тариалангийн системд шилжихэд тариаланчдын зүгээс техник, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын арга хэмжээнд ихээхэн хэмжээний хөрөнгө зарцуулах шаардлагатай болно. Монгол орны цаг уурын нөхцөл нэн хувьсамтгай тул уг хөрөнгө оруулалт нь эргээд тариаланчдын үүрэх эрсдэлийг нэмэгдүүлнэ. Эрсдэлийг бууруулахын тулд тариалангийн даатгал нэвтрүүлэх, мөн төрөөс зохих дэмжлэг үзүүлэх шаардлагатай.



**Ашигласан хэвлэл:**

**Зохиогч:**

Проф., Др. Тобиас Майнел

Amazone Kazakhstan  
010000 Nur-Sultan, Rayon Saryarka, Saifullina  
Street 3, office 1  
Kazakhstan

**Тайлбар:** Энэхүү бодлогын зөвлөмжид багтсан баримт, дүгнэлтийн үнэн зөв байдлыг зохиогч хариуцна. Уг зөвлөмж нь Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” (MNG 19-01) төслийг санхүүжүүлэгч Холбооны Хүнс, хөдөө аж ахуйн яамны албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.